



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2022/54/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр
	Утас: 70483034 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас: 99177546 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn	
Аудитор	Г.Энхдэлгэр
Утас: 70484030 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



БАЯН-УУЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Д.САНСАРБАЯР
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 56
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Татварын тодорхойлолтоор зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй, жилийн эцсийн тооллогоор хөрөнгийг бүрэн тоолж тооцоо бодож, баталгаажуулаагүй, нийгмийн даатгалын тайлангаар илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зэрэг 916.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4 дэх заалт, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07920328

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/	
	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	24.7	206.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,071.2	1,037.1
Нийт хөрөнгийн дүн	1,095.9	1,243.7
Нийт өр төлбөрийн дүн	0	8.6
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,095.9	1,235.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,095.9	1,243.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	613.5	1,266.7
Үйл ажиллагааны зардлын дүн	665.9	1,127.5
Үйл ажиллагааны үр дүн	(52.4)	139.2
Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
Үйл ажиллагааны нийт үр дүн	(52.4)	139.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,095.9	1,099.5
Тайлант оны үр дүн	3.6	139.2
Эцсийн үлдэгдэл	1,099.5	1,235.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	573.5	862.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	569.0	833.8
Үйл ажиллагааны ЦМГ	4.5	28.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(4.5)	(28.4)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	7.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	663.7	634.8
Урсгал зардал	663.7	634.8
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	663.7	642.3
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	617.5	617.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	17.9	16.6
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	28.3	8.3

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулдаг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн тайлан болон татварын цахим систем дэх татварын өглөг, авлагын тооцооллыг хяналаа.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зарцуулалт, норм, бараа материалын тулгалтыг үзэх нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 918.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.4 сая төгрөгийн алдааг залруулж, 916.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд шивүүлээгүй 1.4 сая төгрөгийн төлбөрийн баримтыг нөхөж шивүүлсэн.

Албан шаардлага

Жилийн эцсийн тооллогоор хөрөнгө тоолсон боловч 909.6 сая төгрөгийн хөрөнгийг дүгнэж тооллогын дүнг гаргаагүй, тооцоо бодож баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нийгмийн даатгалын тайлангаар 0.06 сая төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 6.9 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Запуулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	918.0	1	1.4			2	916.6		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	3	918.0	1	1.4			2	916.6		